



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 01/2020

Улаанбаатар хот

Г Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг
дэмжих төв НӨҮГ-ын эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,946,900 /есөн сая есөн зуун дөчин зургаан мянга есөн зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг "Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв" НӨҮГ /Д.Баярсайхан/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 2,500,000 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 10 нэр төрлийн 7,446,900 /долоон сая дөрвөн зуун дөчин зургаан мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг "Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв" НӨҮГ /Д.Баярсайхан/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115030000507

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 06 өдрийн 4/2020 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эргэлтийн бүс хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв" НӨҮГ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-мэргэжилт-ний дүгнэлт	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Байгууллагын вэб сайт	4	ш	1	2,500,000.00	2,500,000.00	2,500,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	Актлах	дахин ашиглахгүй	Устгах	
2	Халаагуур FNS сетктэй	3	ш	1	335,000.00	335,000.00	335,000.00	-	Дахин ашиглах боломжтой	Актлах	ашиглалтын хугацаа дууссан	татах	
3	Халаагуур FN-40 импра	3	ш	1	485,000.00	485,000.00	485,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	Актлах	ажиллахгүй	татах	
4	Телевизор Funai	5	ш	1	600,000.00	600,000.00	600,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	Актлах	ажиллахгүй, дэлгэц шатсан	татах	
5	Агаар чийгшүүлэгч Panasonic	5	ш	1	719,900.00	719,900.00	707,901.47	11,998.53	Дахин ашиглах боломжгүй	Актлах	ажиллахгүй	татах	
6	Компьютер Dell optiplex	5	ш	2	871,000.00	1,742,000.00	1,742,000.00	-	Дахин ашиглах боломжтой	Актлах	ашиглалтын хугацаа дууссан	татах	
Тоног төхөөрөмжийн дүн					5,510,900.00	6,381,900.00	6,369,901.47	11,998.53					
7	Сандал сургалт	9	ш	9	45,000.00	405,000.00	340,875.00	64,125.00	Дахин ашиглах боломжгүй	Актлах	эвдэрхий	татах	
8	Ханын мэдээллийн самбар	9	ш	2	400,000.00	800,000.00	673,333.35	126,666.65	Дахин ашиглах боломжгүй	Актлах	дахин ашиглахгүй	татах	
9	Ширээ сургалт	9	ш	16	95,000.00	1,520,000.00	1,279,333.55	240,666.45	Дахин ашиглах боломжтой	Актлах	муу	татах	
10	Сандал СМТ	5	ш	2	120,000.00	240,000.00	160,000.00	80,000.00	Дахин ашиглах боломжгүй	Актлах	эвдэрхий	татах	

